

УЛААНБААТАР ОРОН СУУЦЖУУЛАЛТ ХХК-ИЙН ДОТООД ХЯНАЛТ,
ШАЛГАЛТЫГ 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 25

Улаанбаатар хот

Д/д	Хийж хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хэрэгжилтийн үр дүн	Хэрэгжилтийн хувь
1	2	3	4	5
1.	Байгууллагын Дотоод хяналт, шалгалтын төлөвлөгөө боловсруулан батлуулах.	2025.04.01-2025.04.03	Байгууллагын Дотоод хяналт, шалгалтын төлөвлөгөөг 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрөөр баталгаажуулан хэрэгжилтийг 100 хувь ханган ажилласан.	100%
2.	Байгууллагын дотоод хяналт, шалгалт хийх ажлын “Удирдамж” боловсруулж батлуулах, хяналт шалгалтын Ажлын хэсгийн бэлтгэл ажил хангах, хэрэгжүүлэх, тайлагнах.	Тухай бүр	Тайлант хугацаанд 2 удаагийн хяналт шалгалтын ажлыг батлагдсан Удирдамжийн хүрээнд амжилттай зохион байгуулж гарсан үр дүнг удирдлагуудад тайлагнан хоблогдох заавар зөвлөмжийг хүргүүлж ажиллав.	100%
3.	Байгууллагын дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах журам боловсруулан батлуулах.	I улиралд	Байгууллагын дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах журмын төлсийг боловсруулан Гүйцэтгэх захирлын 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн А/22 дугаар тушаалаар баталгаажуулан холбогдох албан тушаалтнуудад танилцуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100%
4.	Байгууллагын Гүйцэтгэлийн төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтэд дотоод хяналт, шинжилгээ үнэлгээ хийх дүгнэлт гаргах, удирдлагад танилцуулах.	II, IV улиралд	Тус бодлогын баримт бичгийн 2025 оны жилийн эцсийн хэрэгжилтэд Хяналт- шинжилгээ хийхдээ Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 43 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-д заасан аргачлалын дагуу хийхэд хяналтад авсан 32 заалт Бүрэн хангалттай буюу 95%-тай хэрэгжсэн бөгөөд хэрэгжилтийн балаарх зөвлөмжийг дараахь байдлаар хүргүүлэн ажилласан. 1. Зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг дүгнэж, байгууллагад хэрэгжсэн арга хэмжээний хүрсэн үр дүн, зарцуулсан төсөв хөрөнгө, хэрэгжилтэд нөлөөлж байгаа хүчин зүйл, хэрэгжилт хангалтгүй шалтгааныг бүрэн тусган тайлагнаж хэвшихийг бүх	100%

			албан хаагчдад, 2. "Эрчимжүүлэх шаардлагатай" арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийг сайжруулах хүрээнд удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж ажиллах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг хэлтэс албадын удирдлагад, 3. Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд хэрэгжихгүй байх эрсдэлийг урьдчилан тооцоолж, эрсдэлийг бууруулж ажиллахыг нэгж, албадын удирдлагад, 4. Байгууллагын гүйцэтгэлийн биелэлт болон бусад тайлангийн хэрэгжилтийг тайлагнахдаа өмнөх тайланд тусгасан зөвлөмжийг хангаж, ХШҮ-ний нэгдсэн дүнгээр хангалтгүй хэрэгжсэн хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн заалтуудыг байгууллага, бүтцийн нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд арга хэмжээ болгон тусгаж, хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллахыг бүх албан хаагчдад, тайлан, биелэлтэд хяналт тавьж гарын үсгээр албажуулан тайлагнаж ажиллахыг хэлтэс албадын дарга нарт тус тус зөвлөмж хүргэж ажиллав.	
5.	Хөдөлмөр хамгаалал аюулгүй байдлын чиглэлээр байгууллагын албан хаагчдын хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага хангуулсан эсэх, Хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтэд дүгнэлт гаргах.	II, IV улиралд	Барилга угсралтын төслийг хэрэгжүүлэх явцад Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг дараах 4 хэсгээр мөрдөн ажилласан байна. 1. Мөрдөж буй хууль эрх зүйн хүрээнд 2. ХАБЭА чиглэлийг хариуцлагын гэрээнд тусгасан байдлаар 3. Ажилтнуудыг мэргэшүүлсэн байдлаар 4. Төслийн талбайн хяналт хийсэн байдлаар хэмээн задалж, хууль эрх зүй, стандартын дагуу, ИТА-г мэргэшүүлж, өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж, эрсдэлийг бууруулах чиглэлээр ажилладаг. Орон сууц ашиглалтын албаны ХАБ, орон сууц ашиглалт хариуцсан мэргэжилтэн өдөр тутмын зааварчилгааг ээлжийн ажилтнуудад болон ИТА-уудад өгч, хяналт тавьж эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллаж байна. Одоогоор ХАБЭА-н чиглэлээр санал гомдолгүй ажилласан байна.	100%
6.	Байгууллагын албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт	IV улиралд	Тус байгууллага нь Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 24/16 дугаар тогтоолоор байгуулагдсан бөгөөд ТУЗ-ийн 2025 оны 5 дугаар тогтоолоор бүтэц орон тооны дээд хязгаарыг 76-аар тогтоосон.	100%

	ажлын чиг үүрэгт нийцэж буй эсэх, ажлын байрны стандартад хяналт, үнэлгээ хийх.		Ажилтан, албан хаагчдын Албан тушаалын тодорхойлолтыг Гүйцэтгэх захирлын 2025 оны 08 сарын 19-ний өдрийн А/44 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан бөгөөд мөрдөн ажиллаж байна. Албан тушаалын тодорхойлолтод хяналт, шинжилгээ хийхэд давхардсан чиг үүрэг байхгүй бөгөөд Гэр хорооллын дахин төлөвлөлтийн хэлтэс, Ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцны хэлтсүүдэд албан тушаалын нэрс давхцах бөгөөд чиг үүрэг нь өөр зорилтыг дэвшүүлсэн байна.	
7.	Байгууллагын түр суурьшуулах байруудын ашиглалт, түрээслэгч оршин суугчид болон аж ахуйн нэгж байгууллагуудын гэрээний хэрэгжилтэд дотоод хяналт, шалгалт хийх, зөвлөмж дүгнэлт гаргаж холбогдох хэлтэс, албадад хүргүүлэх, үр дүнг удирдлагад танилцуулах.	IV улиралд	Түр суурьшуулах байр 813, 814, Сэлбэ 50, Баянхошуу 50 орон сууцанд амьдарч буй иргэн, аж ахуйн нэгж байгууллага нь орон сууж болон үйлчилгээний түрээсийн талбайг хүлээн авсанаас хойш түр суурьшуулах гэрээ байгуулсан эсэхээс үл хамаарч тухайн тоот орон сууцанд өөрийн гэр бүлээр амьдарч байгааг тогтоох, гэрээний хугацаа, бичиг баримтын бүрдэл, эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрийг үндэслэж тухайн байранд хамрагдан оршин сууж байгаа талаар хяналт шалгалтыг хийж гүйцэтгэв. Түрээслэж байгаа иргэд тухайн байруудыг 2019 оноос хойш НОСК-тай анх түр суурьшуулах байранд орох гэрээ хийсэн гэх Их өргөө ХХК, Мөнх Ариун булаг ХХК, НОСК, Ивээл цамхаг ХХК, Бармон ХХК, Монкон ХХК, Би Си Ки Си ХХК, Бүтээлч Трезйд ХХК-ийн иргэнтэй гэрээ байгуулж орсон иргэдийн зарим нь тухайн үедээ ямар шийдвэрээр гэрээ байгуулж орсон нь мэдэгдэхгүй тодорхой бус шалтгааны улмаас гэрээний хэрэгжилтийг хангуулахад хүндрэлтэй байгаа тул удирдлагын шийдвэр гарган гэрээ хийсэн байна. Түр суурьшуулах байранд гэрээгээр оршин сууж буй аж ахуйн нэгж, иргэдтэй байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангасан байдалд тулгалт хийхэд Их өргөө ХХК 32 өрх, Мөнх Ариун булаг ХХК 15 өрх, НОСК 9 өрх, Ивээл цамхаг ХХК-9 өрх, Бармон ХХК 2 өрх, Монкон ХХК 1 өрх, УБОС ХХК 1 өрх, Би Си Ки Си ХХК 3 өрх, Бүтээлч Трезйд ХХК 25 өрх, ЖДИ ХХК 1 өрх, Гандан аялал жуулчлал 1 өрх, нийт 103 өрхтэй гэрээ байгуулсан тохиолдолд гэрээний хэрэгжилт бүрэн хангагдана гэж үзэж байна.	100%

			Хяналт шалгалтын хүрээнд түр суурьшуулах 41-р байр /Баянхошуу 50/ давхар түрээслэгч иргэн илэрээгүй тус байрнуудад түрээслэж байгаа аж ахуйн нэгжүүдэд ямар нэгэн зөрчилгүй байна. Түр суурьшуулах байр 813, 814, Сэлбэ 50, Баянхошуу 50 орон сууцуудад амьдарч буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагатай үйлчилгээний түрээсийн талбайг хүлээн авсанаас гэрээ байгуулсан хойш түр суурьшуулах гэрээний хэрэгжилт 2025 оны 11 дүгээр сарын 19-ны өдрийн байдлаар 73,2 хувьтай байна.	
8.	Түр суурьшуулах түрээсийн байрны орлого төвлөрүүлэлтэд хяналт, шалгалт хийж дүгнэлт гарган удирдлагад тайлагнах.	IV улиралд	Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/359, А/360, А/634, А/734 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор СХД-ийн 18 дугаар хороо СТ-4 дүгээр байр, СБД-ийн 6 дугаар хороо 22 дугаар байр, ЧД-ийн 4 дүгээр хорооны 6 дугаар байр, БГД-ийн 2 дугаар хороо 32 дугаар байр, 3 дугаар хорооны 35, 36 дугаар байрны барилга байгууламжийг буулган дахин барилгажуулах төслийг хэрэгжүүлэгч компаниудын гэрээний хэрэгжилт, түр суурьшуулах түрээсийн орон сууцны түрээслэгчдийн өр төлбөр барагдуулах үйл ажиллагааг эрчимжүүлэх ажлыг 2025 оны 10 дугаар сарын 17-ны өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 20-ний өдрүүдэд компанийн Гүйцэтгэх захирлын 2025 оны А/52 тушаалаар батлагдсан Ажлын хэсгийн бүрэлдэхүүн 4 дүүргийн хариуцсан хороод болон түр суурьшуулах түрээсийн байруудын объектод хуваагдан ажиллаа. Түр суурьшуулах байранд гэрээгээр оршин сууж буй аж ахуйн нэгж, иргэдтэй байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангасан байдалд тулгалт хийхэд Их өргөө ХХК 32 өрх, Мөнх Ариун булаг ХХК 15 өрх, НОСК 9 өрх, Ивээл цамхаг ХХК-9 өрх, Бармон ХХК 2 өрх, Монкон ХХК 1 өрх, УБОС ХХК 1 өрх, Би Си Ки Си ХХК 3 өрх, Бүтээлч Трезйд ХХК 25 өрх, ЖДИ ХХК 1 өрх, Гандан аялал жуулчлал 1 өрх, нийт 103 өрхтэй гэрээ байгуулсан тохиолдолд гэрээний хэрэгжилт бүрэн хангагдана гэж дүгнэв.	100%
9.	Байгууллагын өмчийн бүртгэл, тооцоо, ашиглалт, хамгаалалт,	II, IV улиралд	Байгууллагын 2025 оны эхний хагас жилийн өмчийн бүртгэл тооллогыг Гүйцэтгэх захирлын 2025 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн А/38 дугаар тушаалын дагуу 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн 2025 оны 07 дугаар сарын 29-ний өдрүүдэд Төв оффис, 813, 814 дүгээр байр, Баянхошуу 50 айл, Сэлбэ 50	100%

	хадгалалт, санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд дүгнэлт гаргах.		айл байршилд нийт 11 хүний бүрэлдэхүүнтэй хийж гүйцэтгэсэн байна. Үүнд: Үндсэн хөрөнгө: 22,039,603,222.01 (хорин хоёр тэрбум гучин есөн сая зургаан зуун гурван мянга хоёр зуун хорин хоёр төгрөг нэг мөнгө) төгрөгийн үнийн дүнтэй нийт 352 ширхэг хөрөнгө, Бараа материал: 10,284,220.58 (арван сая хоёр зуун наян дөрвөн мянга хоёр зуун хорин төгрөг 58 мөнгө) төгрөгийн үнийн дүнтэй 1785 ширхэг бараа материал, Мөнгөн хөрөнгө: байгууллагын кассад нийт 252,152.16 (хоёр зуун тавин хоёр мянга нэг зуун тавин хоёр төгрөг арван зургаан мөнгө) төгрөг тус тус бүртгэсэн байна. 2025 оны жилийн эцсийн тооллогыг Гүйцэтгэх захирлын 2025 оны 12 сарын 26-ны өдрий А/56 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсэг хийж гүйцэтгэж байгаа бөгөөд нэгдсэн дүн гараагүй байна. Мөн хагас жилээр тоологдсон актлах эд хөрөнгийн бүртгэлийг үүсгээгүй бөгөөд байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцүүлээгүй байна.	
10.	Хөрөнгө оруулалтын ажил, Худалдан авах ажиллагаанд хяналт, үнэлгээ хийж дүгнэлт гарган удирдлагад тайлагнах.	II, IV улиралд	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу 2025 онд нийт 314,445,975 төгрөгийн худалдан авалт хийсэн ба Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолын дагуу төсөвт өртгийн дээд хязгаарыг баримтлан ажилласан байна. Нээлттэй ил тод байдлыг хангах зорилгоор www.shilendans.gov.mn сайтад цаг тухай бүрт 5 саяас дээшхи үнийн дүнтэй худалдан авалтын холбогдох мэдээллийг байршуулсан байна.	100%
11.	Байгууллагын албан хаагчдын ажлын цаг ашиглалт, цаг бүртгэлийн системийн бүртгэлд хяналт шинжилгээ хийж дүгнэлт гарган удирдлагад тайлагнах.	II, IV улиралд	Ажилтан, албан хаагчдын цагийн бүртгэлийг er.ulaanbaatar.mn системийн “Цаг бүртгэл” дэд системээр өдөр бүр хяналт тавьж, хяналт-шинжилгээ үнэлгээ хийж тайлан мэдээг сард 2 удаа удирдлагад танилцуулан, цагийн бүртгэлийн зөрчилтэй хэлтэс албадын ажилтан албан хаагч нарт тухай бүр зөвлөмж хүргүүлж ажилласан.	100%

12.	Төлөвлөгөөний дагуу хийсэн ажлын биелэлтийг тухай бүрт илтгэх хуудсаар удирдлагад тайлагнаж, үйл ажиллагааны зөрчил, дутагдал арилгах.	Тухай бүрт	Төлөвлөгөөний дагуу хийсэн 2 удаагийн Удирдамжаар баталгаажсан төлөвлөгөөт хяналт, шалгалт болон цаг үеийн хяналт үнэлгээний танилцуулгыг тухай бүр байгууллагын удирдлагад танилцуулж мөн шаардлагатай мэдээллийг дээд газарт илгээж ажиласан.	100%
-----	--	------------	---	------

ХЯНАСАН:

ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА  Ж.БАЛЖИННЯМ

БОЛОВСРУУЛСАН:

ЗАХИРГААНЫ АХЛАХ, ДОТООД ХЯНАЛТ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН 

Т.ЭНХМАА